

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

Агуулга.....	1
1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн Хөгжлийн банк



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН
ШИНЭЧЛЭЛ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Л.БАТТӨГӨЛДӨР
ТАНАА

2020.05.01 № 06/1477
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төлбөрийн системийн шинэчлэл төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Төлбөрийн системийн шинэчлэл төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Төлбөрийн системийн шинэчлэл төслийн 2019 оны санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Төлбөрийн системийн шинэчлэл төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Л.Баттөгөлдөр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын үр дүнд үндэслэн Шилэн дансны тухай хуулийг дагаж мөрдөх талаарх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төлбөрийн системийн шинэчлэл төслийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төлбөрийн системийн шинэчлэл төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 04 дүгээр сарын 06-наас 2020 оны 04 дүгээр сарын 24-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Далайван Аудит ХХК-ийн захирал Ц.Жигдэн хянан удирдаж, чанарын хяналтын менежер М.Болормаа, аудитор Ц.Ганболд, аудиторын туслах Н.Энхцэцэг нар хэрэгжүүлэв.

Төлбөрийн системийн шинэчлэл төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр хуулийн хугацаанд хүргүүлсэн байна. Далайван Аудит ХХК нь 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 9 тоот албан бичгээр төслийн нэгжийн санхүүгийн тайланг хүлээн авч аудитын ажлыг эхлүүлсэн.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Засгийн Газар, АХБ хооронд 2014 оны 03 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан зээлийн хэлэлцээрээр “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл”-ийг хэрэгжүүлэхэд АХБ-ны Энгийн эх үүсвэрээс санхүүжигдэх 20,000,000 ам.долларын МОН-3072 дугаартай зээлийг олгохоор болсон. Зээлийн гэрээг УИХ-аас 2015 оны 06 дугаар сарын 25-ны өдөр соёрхон баталж, 2015 оны 08 дугаар сарын 14-ний өдөр хүчин төгөлдөр болсон.

АХБ-ны зээлийн хөрөнгийн ашиглалтын нөхцөлд тусгагдсаны дагуу Дамжуулан зээлдэх 0716/224 тоот гэрээг Сангийн Яам болон Монголбанк хооронд 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр байгуулсан. Дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулах үйл явц удааширсантай холбоотойгоор зээлийн гэрээний дуусах хугацаа 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдөр байсныг 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр болгон сунгасан бөгөөд 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн гэрээний өөрчлөлтөөр зээлийн хаах хугацааг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл дахин сунгасан.

Төслийн зорилго нь: Төслийн үр дүнд санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн баримтлах зарчим болон үнэт цаасны төлбөр тооцооны системийн зөвлөмжид нийцсэн үр ашигтай, найдвартай, харилцан уялдаа бүхий төлбөрийн системийн дэд бүтцийг бий болгон төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

Тайлант хугацаанд санхүүгийн байгууллагуудад зориулсан тоон гарын үсгийн систем, банк хоорондын бага дүнтэй гүйлгээний АСН+ систем нэвтрүүлэх, үндэсний цахим гүйлгээний төвийн Дархан-Уул аймаг дахь нөөц дата төвийг шинэчлэх ажлуудыг хийж дуусган хүлээн авагч байгууллагад хүлээлгэн өгсөн байна.

Төлбөрийн системийн шинэчлэл төслийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Сангийн сайдын 2015 оны 196 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”
- Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”
- Сангийн сайдын 2007 оны 326 тоот тушаалаар батлагдсан “Засгийн газрын шугамаар авч, ашиглаж буй хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, засгийн газрын тусгай санд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал”

Тайлант хугацаанд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон;

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Төслийн нэгж нь өөрийн үйл ажиллагаанд тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй байна.

Төлбөрийн системийн шинэчлэл төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Инфосистемс” ХХК-ийн “Пакс” программ хангамж ашиглаж байна.

Төлбөрийн системийн шинэчлэл төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

Төсөл нь төлөвлөсөн үйл ажиллагааг тогтоосон хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлэх, зээлийн хөрөнгийг зорилгын хүрээнд үр ашигтай зарцуулах, хэрэгжилтэд хяналт тавих, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, ил тод байдлыг хангахын тулд төслийн гүйцэтгэлийн хяналт, санхүүгийн хяналт, худалдан авах үйл ажиллагааны хяналтыг хэрэгжүүлдэг. АХБ болон Төслийн гүйцэтгэгч байгууллагаас төслийн үйл ажиллагааны үе шат бүрт хяналт тавьж ажилладаг.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Төлбөрийн системийн шинэчлэл төслийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын гүйцэтгэлийн үе шатанд 2 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Нийт зардлын дүнг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь төсөл хэрэгжүүлэх нэгж нь АХБ-ны зээлийн санхүүжилтээр орлогын эх үүсвэрийг бүрдүүлдэг тул нийт зардлаас тооцох нь илүү оновчтой гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 9,114,700.7 мянган төгрөгөөс 182,294.0 мянган төгрөгөөр тооцон материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өөрчлөөгүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Төлбөрийн системийн шинэчлэл төслийн 2019 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,860,459.0 мянган төгрөгөөр буюу 47.11 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилж гарсан зардал, богино хугацаат өр төлбөр, хуримтлагдсан үр дүн дансдууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,902,028.3	4,270,903.4	368,875.1
Авлага	575.0	-	(575.0)
Урьдчилж гарсан зардал	4,211,524.5	-	(4,211,524.5)
Үндсэн хөрөнгө	102,009.5	102,009.5	-
Хуримтлагдсан элэгдэл	(26,583.7)	(42,193.3)	(15,609.6)
Биет бус хөрөнгө	6,500.0	6,500.0	-
Хуримтлагдсан элэгдэл	(2,437.5)	(4,062.5)	(1,625.0)
Нийт хөрөнгө	8,193,616.1	4,333,157.1	(3,860,459.0)
Богино хугацаат өр төлбөр	977,939.4	15,897.5	(962,041.9)
Хуримтлагдсан үр дүн	8,193,616.1	4,333,157.1	(3,860,459.0)
Өмнөх оны үр дүн	2,063,892.3	7,215,676.7	5,151,784.4
Тайлант оны үр дүн	5,151,784.4	(2,898,417.1)	(8,050,201.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,193,616.1	4,333,157.1	(3,860,459.0)

Мөнгөн хөрөнгө: Төсөл нь тайлант хугацааны эцэст ам.долларын дансны үлдэгдэл 4,245,514.6 мянган төгрөг, төгрөгийн дансдын нийт үлдэгдэл 25,388.8 мянган төгрөг тайлагнасан байна.

Урьдчилж гарсан зардал: Тайлант хугацаанд санхүүгийн байгууллагуудад зориулсан тоон гарын үсгийн систем, банк хоорондын бага дүнтэй гүйлгээний АСН+ систем, үндэсний цахим гүйлгээний төвийн Дархан-Уул аймаг дахь нөөц дата төвийг шинэчлэх ажлуудын төлбөрт 3,520,885.5 мянган төгрөгийг төлж, нийт 7,732,410.0 мянган төгрөгийн хөрөнгийг хүлээн авагч байгууллагад хүлээлгэн өгснөөр тус данс үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө: Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр төслийн нэгжийн үйл ажиллагаанд зориулан худалдан авсан компьютер, тавилга эд хогшлыг үндсэн хөрөнгөөр, санхүүгийн программ хангамжийг биет бус хөрөнгөөр тус тус бүртгэсэн. Тайлант хугацаанд үндсэн хөрөнгөд 15,609.6 мянган төгрөгийн, биет бус хөрөнгөд 1,625.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулж зардлаар бүртгэсэн.

Богино хугацаат өр төлбөр: Төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнуудын цалин болон олон улсын зөвлөхүүдийн цалинд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн дагуу тооцож суутгасан татварын өглөгийг бүртгэсэн.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төлбөрийн системийн шинэчлэл төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг санхүүжүүлэхэд зориулан тайлант онд 5,801,183.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 4,976,381.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан.

Хүснэгт 2. Төслийн орлого

/ мянган төгрөг/

Санхүүжилтийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	5,801,183.4	4,976,381.0	824,802.4	85.78
Нийт дүн	5,801,183.4	4,976,381.0	824,802.4	85.78

Төсвийн зардлын гүйцэтгэл 4,715,474.7 мянган төгрөг буюу 81.28 хувьтай буюу төслийн үйл ажиллагааны зардал 1,085,708.7 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь нөлөөлжээ.

Хүснэгт 3. Төслийн зардал

/ мянган төгрөг/

Санхүүжилтийн төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	5,801,183.4	4,715,474.7	1,085,708.7	81.28
Нийт дүн	5,801,183.4	4,715,474.7	1,085,708.7	81.28

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлсэн орлогын гүйцэтгэлийг төлөвлөлттэй уялдуулан төсвийн хүрээнд зүй зохистой зарцуулсан.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 2 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 1 эрсдэл тодорхойлж нийт 3 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 108,143.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 108,143.7 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч Менежментийн захидалд тусгалаа.

Аудитын явцад санхүүгийн тайланд дараах залруулгыг хийв. Үүнд:

Тайлант хугацаанд Монголбанкны үндэсний цахим гүйлгээний төвийн Дархан-Уул аймагт байрлах нөөц дата төвийг шинэчлэх гэрээт ажлын хүрээнд МУ-ын Засгийн газраас 107,977.5 мянган төгрөгийн НӨАТ-ыг чөлөөлөлт хэлбэрээр санхүүжүүлэн олгосон. Тус НӨАТ-ын чөлөөлөлтийг хөрөнгийн өртөгт оруулж бүртгээгүй, тайлант хугацааны зардлаар бүртгэсэн, Энэ нь иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүйгээс гадна УСНББОУС 17 - Үндсэн хөрөнгөд "Үндсэн хөрөнгийн өртөгт гаалийн татвар, буцаан олгогдохгүй худалдааны татвар багтсан худалдан авсан үнэ багтана" гэсэнтэй нийцэхгүй байна.

Тайлант хугацаанд тендерийн орлогын дүнгээс тендерийн зардлыг хасч цэвэр дүнгээр бүртгэж санхүүгийн үр дүнгийн тайланг 166.2 мянган төгрөгөөр орлого болон зардлыг дутуу илэрхийлсэн байна. Энэ нь иж бүрэн байх, тодруулга ба толилуулга батламж мэдэгдлүүдийг хангаагүй ба Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал"-тай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар дор дурдсан асуудлуудыг анхаарч үзэх шаардлагатай. Үүнд:

- Төсвийн тухай хуульд олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага тул нягтлан бодох бүртгэлээ УСНББОУС-ын дагуу бүрэн

аккруэл суурь ашиглан бүртгэх шаардлагатай болсон. Иймд олон улсын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд тохирсон нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын нэгдсэн заавар, аргачлалыг Сангийн яамнаас тусгайлан гаргах хэрэгтэй байна. Уг заавар, аргачлалд төслийн нэгж нь АХБ-ны зарцуулалтын үндсэн процедур болох шууд төлбөр, урьдчилгаа төлбөр, нөхөн дүүргэлтийг аккруэль сууриар хэрхэн хүлээн зөвшөөрч бүртгэж тайлагнах, хүлээн авсан болон зарцуулсан санхүүжилтэнд гадаад валютын ханшийг хэрхэн ашиглах, төслийн санхүүжилтээр бий болсон биет болон биет бус хөрөнгийн элэгдүүлэх хугацаа болон арга, төслийн санхүүжилтээр хийгдэж байгаа барилга, байгууламж, тоног төхөөрөмжийг хэрхэн хуримтлуулан бүртгэх, хөрөнгийг төсөл дуусахад төрийн өмчид шилжүүлэх, зээл тусламжийг төслийн нягтлан бодох бүртгэлд өр төлбөрөөр тусгах эсэх, зээлийн хүүний өр төлбөрийг хэрхэн бүртгэх;

- Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд шаардсан мэдээллийг бүрэн оруулсан эсэхийг хянах;
- Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн төлөвлөгөө болон төсвийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг эдийн засгийн ангиллаар нь задалж тайлагнаж байгаа эсэхийг хянах;

2.12. Шилэн дансны мэдээлэл

Төлбөрийн системийн шинэчлэл төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу нийт 107 мэдээллийг оруулахаас 73 мэдээллийг хугацаанд нь, 33 мэдээллийг хугацаа хоцроон, 1 мэдээллийг оруулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 295.4 мянган төгрөгийн зөрчилд хүргүүлсэн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Төлбөрийн системийн шинэчлэл төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Төлбөрийн системийн шинэчлэл төслийн 2019 оны санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Шилэн дансны мэдээллийн талаар

3.1.1 Илрүүлэлт:

Төлбөрийн системийн шинэчлэл төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу нийт 107 мэдээллийг оруулахаас 73 мэдээллийг хугацаанд нь, 33 мэдээллийг хугацаа хоцроон, 1 мэдээллийг оруулаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Шилэн дансны тухай хууль зөрчих, мэдээлэл буруу орох.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу мэдээллийг тогтсон хугацаанд нь бүрэн гүйцэт оруулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,114,127,849.79	4,270,903,426.29
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,902,028,316.17	4,270,903,426.29
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,902,028,316.17	4,270,903,426.29
31210	Төгрөг	15,971,012.51	25,388,802.51
31213	Арилжааны банк дахь харилцах	15,971,012.51	25,388,802.51
31220	Гадаад валют	3,886,057,303.66	4,245,514,623.78
31222	Монгол банк дахь харилцах	3,692,668,609.97	4,233,133,472.97
31223	Арилжааны банк дахь харилцах	193,388,693.69	12,381,150.81
33	АВЛАГА	574,991.04	0.00
33500	Бусад авлага	574,991.04	0.00
33510	Байгууллагаас авах авлага	574,991.04	0.00
34	УРЬДЧИЛГАА	4,211,524,542.58	0.00
34600	Урьдчилж гарсан зардал	4,211,524,542.58	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	79,488,262.77	62,253,690.33
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	79,488,262.77	62,253,690.33
39200	Биет хөрөнгө	75,425,762.77	59,816,190.33
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	72,898,909.96	72,898,909.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	(21,647,546.54)	(34,346,057.35)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,110,616.27	29,110,616.27
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,936,216.92)	(7,847,278.55)
39300	Биет бус хөрөнгө	4,062,500.00	2,437,500.00
39301	Програм хангамж	6,500,000.00	6,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,437,500.00)	(4,062,500.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,193,616,112.56	4,333,157,116.62
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	977,939,353.27	15,897,494.42
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	977,939,353.27	15,897,494.42
41300	Өглөг	0.00	15,897,494.42
41360	Бусад өглөг	0.00	15,897,494.42
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	0.00	15,897,494.42
41400	Урьдчилж орсон орлого	977,939,353.27	0.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	977,939,353.27	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,215,676,759.29	4,317,259,622.20
51	Засгийн газрын хувь оролцоо	7,215,676,759.29	4,317,259,622.20
51200	Хуримтлагдсан үр дүн	7,215,676,759.29	4,317,259,622.20
51210	Өмнөх үеийн үр дүн	2,063,892,340.87	7,215,676,759.29
51220	Тайлант үеийн үр дүн	5,151,784,418.42	(2,898,417,137.09)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,193,616,112.56	4,333,157,116.62

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,156,790,796.39	6,108,281,107.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,156,790,796.39	6,108,281,107.36
120	Нийтлэг татварын бус орлого	6,156,790,796.39	6,108,281,107.36
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,156,790,796.39	6,108,281,107.36
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	86,344,710.88	201,269,639.61
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	6,070,446,085.51	5,907,011,467.75
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	811,953,516.45	1,376,482,031.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	811,953,516.45	1,376,482,031.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	804,174,163.49	1,371,753,577.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	274,943,889.36	339,046,363.64
210101	Үндсэн цалин	274,943,889.36	339,046,363.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,991,150.40	42,380,795.46
210201	Тэтгэврийн даатгал	21,995,511.15	28,818,940.91
210202	Тэтгэмжийн даатгал	2,749,438.89	3,390,463.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,197,434.79	2,712,370.91
210204	Ажилгүйдлийн даатгал	549,887.78	678,092.73
210205	Эрүүл мэндийн даатгал	5,498,877.79	6,780,927.27
2103	Байр ашиглалттай холбоотой зардал	32,067,000.00	35,280,000.00
210304	Байрны түрээс	32,067,000.00	35,280,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,839,006.93	20,850,094.93
210401	Бичиг хэрэг	3,199,558.26	3,800,161.72
210402	Тээвэр, шатахуун	1,327,272.73	2,659,090.91
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,357,270.90	7,413,281.54
210404	Ном, хэвлэл	6,982,951.65	3,571,072.70
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,971,953.39	3,406,488.06
2107	Томилолт, зочны зардал	2,385,707.00	2,175,252.00
210701	Гадаад албан томилолт	717,879.00	0.00
210702	Дотоод албан томилолт	1,667,828.00	2,175,252.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	280,293,760.12	596,837,883.94
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	416,755.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,096,913.09	13,407,051.68
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	272,701,047.62	582,008,187.87
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	293,144.41	279,884.39
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	0.00	166,160.00
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	2,185,900.00	976,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	165,653,649.68	335,183,187.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	149,686,028.22	317,948,615.02
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,967,621.46	17,234,572.44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,779,352.96	4,728,453.98
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт	7,779,352.96	4,728,453.98
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	7,779,352.96	4,728,453.98
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	5,344,837,279.94	4,731,799,075.95
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	95,566,053.09	108,168,654.92
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	95,566,053.09	108,168,654.92
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	288,618,914.61	7,738,384,867.96
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	0.00	5,974,828.66
225005	Хаагдсан данс	288,618,914.61	7,732,410,039.30
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	5,151,784,418.42	(2,898,417,137.09)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	7,094,883,796.70	4,976,380,973.68
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,094,883,796.70	4,976,380,973.68
120	Нийтлэг татварын бус орлого	7,094,883,796.70	4,976,380,973.68
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,094,883,796.70	4,976,380,973.68
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,498,357.92	53,283,687.85
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	7,048,385,438.78	4,923,097,285.83
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,094,883,796.70	4,976,380,973.68
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	16,852,706.27	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	16,852,706.27	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	16,852,706.27	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	16,852,706.27	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(16,852,706.27)	0.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(5,161,291,937.17)	(4,607,505,863.56)
14	Бусад эх үүсвэр	95,566,053.09	108,168,653.00
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	95,566,053.09	108,168,653.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	5,256,857,990.26	4,715,674,516.56
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	5,256,857,990.26	4,715,674,516.56
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,916,739,153.26	368,875,110.12
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,985,289,162.91	3,902,028,316.17
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,902,028,316.17	4,270,903,426.29

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
					Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2017 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,063,892,340.87	2,063,892,340.87
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	2,063,892,340.87	2,063,892,340.87
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	5,151,784,418.42	5,151,784,418.42
10	2018 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	7,215,676,759.29	7,215,676,759.29
11	2019 оны 1 дүгээр сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	7,215,676,759.29	7,215,676,759.29
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	7,215,676,759.29	7,215,676,759.29
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	(2,898,417,137.09)	(2,898,417,137.09)
20	2019 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	4,317,259,622.20	4,317,259,622.20

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэлийн зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,801,183,400.00	4,715,674,516.56	1,085,508,883.44	81.29
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	5,801,183,400.00	4,715,674,516.56	1,085,508,883.44	81.29
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	5,801,183,400.00	4,715,674,516.56	1,085,508,883.44	81.29
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,801,183,400.00	4,976,380,973.68	824,802,426.32	85.78
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,801,183,400.00	4,976,380,973.68	824,802,426.32	85.78
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	53,283,687.85	(53,283,687.85)	100.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	0.00	0.00	0.00	0.00
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	5,801,183,400.00	4,923,097,285.83	878,086,114.17	84.86
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	3,902,028,316.17		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	4,162,734,773.28		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО		6.00		
620004	Гэрээт ажилтан		6.00		

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.04.27	Аудитын нэр: Төлбөрийн системийн шинэчлэл төслийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: САГ-2020/730/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр: Төлбөрийн системийн шинэчлэл төсөл	Мянган төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Төсөл нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу нийт 107 мэдээллийг байршуулахаас 73 мэдээллийг хугацаанд нь, 33 мэдээллийг хугацаа хоцроон, 1 мэдээллийг байршуулаагүй байна.	-	Зөвлөмж өгөх	Төслийн зохицуулагч	Л.Баттөгөлдөр
	Зөвлөмжийн дүн	-			

